

Бид ч бас шинжээч!

олон нийтийн судалгааг дэмжих

ХЯНАЛТЫН ЖАГСААЛТ



INTERNATIONAL
ACCOUNTABILITYPROJECT

Энэхүү товхимол нь Олон нийтийн судалгааг явуулах зааварт заасан гол стратеги болон зөвлөмжүүдийн хураангуй юм. Судалгааны загварыг та уг Хянах жагсаалтын хамт орон нутгийнхаа онцлогт тохируулан ашиглах боломжтой.



Заавар



Жагсаалт



Загвар

Олон нийтийн судалгаа гэж юу вэ?

Та "судалгаа" гэх үгийг сонсоод юу гэж боддог вэ? Судалгаа нь танаас холуур бусдын хийдэг зүйл гэж боддог уу? Үүнийг зөвхөн их сургуулийн профессорууд хийдэг, танд хүртээлгүй зүйл үү?

Судалгаа нь заавал тийм зүйл байх албагүй. Судалгаа нь хамт олны хүчин чармайлт, олон нийт өөрийн хүссэн сэдвээр судалгааг сонгох, чиглүүлж зохион байгуулах эрх мэдэлтэй байх, оролцсон хүн бүр цуглуулсан мэдээллээр хувь нэмэр оруулах, солилцох, түүнийгээ түгээх эрх чөлөөтэй байвал зохино.

Меконг голын орон нутгийн хүрээлэн нь олон нийтэд түшиглэсэн судалгаагаа "олон нийтийн тусын тулд орон нутгийн туршлагад тулгуурласан мэдлэгийг эрэлхийлэх үйлс" гэж тодорхойлдог. Бусад төрлийн судалгаа нь орон нутгаас гадуур асуугддаг асуултуудаас эхэлдэг тул өөр.

Олон нийтийн судалгааны сэдэв, асуултууд, процессыг нутгийн иргэд өөрсдөө тодорхойлсноор, өөрсдийн туршлага, мэдлэгийг хуримтлуулж, улмаар дүн шинжилгээ хийх, тайлбарлах боломжийг олж авна. Олон нийтийн судалгаа хийснээр орон нутгийн мэдлэг, зан үйл, заншлыг тогтоож олсон мэдлэгээ ашиглана. Орон нутгийнхан нь судалгааны зөвхөн сэдэв буюу объект байх ёсгүй. Зөвхөн судлаачид, эрдэмтэд биш олон нийт ч **шинжээч байж болно!**

Үнэн хэрэгтээ, нутгийнхан өөрсдийнхөө судалгааг хийдэг бол бусдын олж хараагүйг илрүүлэх илүү магадлалтай. Орон нутгийн иргэд нь орчин тойрныхоо тухай шийдвэр гаргагч, төлөвлөгчдөөс илүү мэдлэгтэй байх магадлал өндөр. Ихэнхдээ, судалгааны үр дүн нь иргэдэд өөрсөдөө тулгарч буй асуудлуудыг илүү ойлгох, санал, бодолдоо итгэлтэй болох, эв нэгдэл, хамтын хариуцлагатай, олон нийтийн зохион байгуулалтанд орох чадварыг олгож тусалдаг. Судалгаагаар олсон туршлага, мэдлэг нь олон нийтийн кампанит ажил явуулахад тус болох ач холбогдолтой.

Олон нийтийн судалгаанууд нь хөгжлийн өөр хувилбарууд байж болохыг харуулж, хөгжлийн явцыг нутгийнхан хүч түрэн орж өөрчлөх боломжтойг харуулна. Орон нутгийн иргэд хөгжлийн үйл явцын төвд өөрсдийгөө болон өөрсдийн үзэл бодлыг тавибал олон нийтийн судалгаа нь хүчирхэг хэрэгсэл болно!

Олон нийтийн судалгааны арга барилууд дээр үндэслэн орон нутгийн судалгаа шинжилгээний ажлыг хийхээр зэхэж буй нийгэмлэгүүд, олон нийтийн зохион байгуулагчид, орон нутгийн иргэний нийгмийн бүлгүүдэд дэм болгож энэхүү Хяналтын жагсаалтыг түншүүдийн хамт боловсруулав.

Хяналтын жагсаалтад олон нийтийн судалгааг ашиглан нутгийнхаа хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох алхамуудыг заасан болно.

Орон нутагт судалгаа хийх процесст **бэлтгэх, судлах, сурталчлах** гол алхмууд орно.

1	Бэлтгэх	<ol style="list-style-type: none">1. Судалгааны сэдвийг олох2. Судалгааны баг бүрдүүлэх3. Холбоотон, нөлөөлөх эздийг олох4. Аюулгүй байдлыг хангах5. Судалгааны арга хэрэгслийг боловсруулах
2	Судлах	<ol style="list-style-type: none">6. Нийгэмлэгийг бүхэлд нь хамруулах7. Мэдээллийг цуглуулах8. Дүгнэлт, саналын төслийг боловсруулах9. Төслийг танилцуулж хариу санал авах
3	Сурталчлах	<ol style="list-style-type: none">10. Эцсийн дүгнэлт, саналын төслийг танилцуулах11. Хамтдаа арга хэмжээ авах12. Үр нөлөөллийн эцсийн дүгнэлт гаргах

IAP нь санал бодлоо хуваалцсан Эмэгтэйчүүдийн Хууль, Хөгжлийн асуудлаарх Ази Номхон Далайн форум болон Меконг Орон нутгийн хүрээлэнд талархаж байна.



БЭЛТГЭХ

1. Судалгааны сэдвийг тодорхойлох

Судалгааны гол сэдвийг олохын тулд аль болох олон хүний оролцоотой **нутгийн хамт олны уулзалт** буюу хэд хэдэн ярилцлага зохион байгуулж хэлэлцэх. Эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл буюу гадуурхагдан хоцордог бусад бүлгүүдийг оролцуулахыг чухалчлах.

Уулзалтаа төлөвлөхдөө нийгэмд **тулгарч буй асуудлуудыг нийтээрээ хэлэлцэх уулзалт зохион байгуулах нь аюултай эсэхийг цэгнэх нь чухал**. Эрх мэдэлтнүүдийн анхаарлыг татахаас зайлсхийхийн тулд байршлыг зөв сонгох хэрэгтэй. Тухайлбал, сүм хийдийн уламжлалт цугларалт, эсвэл олон нийтийн тогтмол арга хэмжээ гэх мэт. Олон нийтийн итгэлтэй удирдагчдыг олж тогтоон, зөвлөлдөх. Хэрэв том уулзалт хийхэд эрсдэлтэй бол төрөл бүрийн бүлэг хүмүүстэй албан бус ярилцлага хийх байдлаар эхлэж болно.

Уулзалтаар **судалгааны сэдвийг тодорхойлж**, юу мэдэхийг хүсч байгаагаа тодорхойлох. Судалгааг хэрхэн гүйцэтгэх, ямар үүрэг гүйцэтгэх, ямар хэрэгсэл байгааг судлах, судалгаанд хэдий бодит цаг зарцуулах зэрэг асуудлыг шийдэх.

Таны тодорхойлж буй сэдвийг хөгжлийн банк, төсөл хэрэгжүүлэгчид, засгийн газар өөр өөрөөр харж болно. Тэдгээрийн төсөөлөл буруу эсвэл дутагдалтай гэж үзвэл тэдний санааны бурууг зааж, сорьж болно. Жишээлбэл,

Төслийн "албан ёсны баримт бичиг"-т хүний эрх буюу хүрээлэн буй орчинд одоо буюу ирээдүйд нөлөөлөх нөлөөллийн талаарх мэдээлэл нь үгүй, хасагдсан буюу буруугаар орсон бол олон нийтийн судалгаа явуулагчид нөхөн оруулж болно.

Асуудлыг тодорхойлох болон шинжлэх:

Орон нутгийн арга хэмжээ зохион байгуулах, олон нийтийг зохион байгуулахад бусдыг сургах арга хэрэгсэл, зөвлөгөө өгөх “Эх сурвалжийн хайрцаг”



Эх сурвалжийн
хайрцаг



bit.ly/ComAnalyze

Тосгоны ном: ActionAid-ээс боловсруулсан Тосгоны номонд хүмүүс өөрсдийн тосгонд нүүрлэж буй асуудлуудын шалтгааныг олохын тулд нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, баримтжуулах аргыг заана.



bit.ly/VillageBookActionAid

2. Судалгааны багийг бүрдүүлэх

Судалгааны баг бүрдүүлэх асуудлаар нутгийн нийт хамт олонд хандах. Багийн гишүүд өргөн олон нийттэй мэдээлэл солилцож, асуулга явуулж, цуглуулсан мэдээллийг эмхэтгэнэ. Баг нь нийт олны бүх бүлэг, ялангуяа цөөнх буюу орхигдсон хүмүүсийг оролцуулвал зохино. Багийн гишүүдийн тоо судалгааны хүрээнээс хамаарах боловч хамгийн багаар бодоход 10 хүн шаардлагатай болно.

Багаа сургаж авах нь маш чухал. Энэ судалгааны ажлыг олон нийтийн зүгээс яагаад хийх болсон вэ? судалгааны зорилго юу вэ?, гишүүн бүрийн үүрэг хариуцлага ямар байх? талаар нийт багийнхантайгаа хамтдаа ойлголцох. Багийн гишүүд оролцогч олон нийттэй нэг нэгээр нь буюу жижиг бүлгүүдтэй харилцан ярилцах, асуулга явуулах бэлтгэлтэй байвал зохино. Судалгааны үйл явц нь мэдээллийн солилцоо тул оролцогчдод асуулт асуух магадлалтай гэдгийг санаж явах хэрэгтэй. Багийн гишүүн бүр судалгааныхаа сэдэв болон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний талаар ойлголттой байх хэрэгтэй.



Эх сурвалжийн
хайрцаг

Олон нийтэд түшиглэсэн судлаачдын сургалтын гарын авлага: Орон нутгийн судлаачдад зориулсан сургалтын гарын авлага, үүнд судалгааны зорилтот агуулгыг тогтох ба асуулга, ярилцлага, чиглэлт бүлгүүд зэрэг судалгааны арга зүйг танилцуулна.

→ bit.ly/CBPRManual

3. Холбоотон, нөлөөлөх эздийг олох

Судалгааны багаас гадна өөр холбоотнууд судалгааны үйл явцад хувь нэмрээ оруулах боломжтой. Танай нийгэмлэгийн гишүүд ажилтай байх эсвэл судалгааны бүх үе шатанд бүрэн оролцох цаг завгүй байж болох юм. Ийм тохиолдолд их сургуулийн оюутнууд болон орон нутгийн иргэний нийгмийн бүлгүүдтэй холбоо тогтоох нь тустай байж болно. Жишээ нь, их сургуулийн итгэлтэй оюутнаар судалгааны аргачлалыг боловсруулах эсвэл мэдээллийг боловсруулах систем, програм зохиолгож болно. Ижил төсөл эсвэл тухайн компани, банкны төсөлтэй тулгарсан, эсвэл ижил төстэй судалгаа явуулсан хүмүүсээс зөвлөгөө, дэмжлэг авах.

Орон нутгийн, үндэсний болон олон улсын иргэний нийгмийн байгууллагууд нь судалгаа шинжилгээний нэмэлт мэдээллээр хангах мөн судалгаа дуусахад зорилтот хэрэглэгч, шийдвэр гаргагчдад хүргэх мессежийг чангатгах ач холбогдолтой. Таны итгэл хүлээсэн засгийн газрын гишүүд болон судлаачид дүн шинжилгээ хийх, гол үр дүн, өргөн хүрээнд чиг хандлагыг тодорхойлоход тусална. Зорилгоос шалтгаалан судалгааны үр дүнг график, бичмэл тайлан эсвэл видео хэлбэрээр гаргахад туслах нэмэлт холбоотнууд ч байж болно.

Хэрэв нийтэд аюул хүргэхгүй, судалгаа, кампанит ажилд сөргөөр нөлөөлөхгүй бол судалгаанд буюу хэсэгт нь нөлөөлж болох гол шийдвэр гаргагчидтай холбоо барьж болох юм. Тэдэнд юу нөлөөлдгийг судалж, тэдэнтэй хэрхэн харьцах талаар урьдчилан шийдэх хэрэгтэй. Жишээлбэл, холбоотнууд болон шийдвэр гаргагчдын өөр хоорондын харилцааны зураглалыг гарган шинжиж кампанит ажлын зорилгодоо хүрэх бодлогоо зохицуулж чадна. Дахин хэлэхэд, кампанит ажилд аюулгүй, үр өгөөжтэй гэж үзвэл судалгааныхаа талаар уулзалдаж буюу

утсаар мэдээ хүргэж, тэдэнтэй харилцаа сайтай бол энэхүү судалгаанаас тэд авах хүсэлтэй байгаа мэдээллийн талаар асуух. Холбоотон болон шийдвэр гаргагчдад хүрэхийн өмнө аюулгүй байдлыг шинжиж, тодорхой, энгийн мэдээллээр харилцах болно гэдгээ урьдчилан тогтох. Мөн харилцаа холбоог аль болох боломжтой баримтжуулж, зохион байгуулах ба уулзалт, ярилцлагын бичмэл тэмдэглэл хөтлөж байх чухал.



RESOURCE
BOX

Эх
сурвалжийн
хайрцаг

Албадан нүүлгэх, нүүлгэн шилжүүлэлтийг хамарсан төслүүд дээр хэрхэх талаар

НҮБ-ын Тусгай Илтгэгчээс Зохиомжтой орон сууцны асуудлаар бэлтгэсэн энэ ажлын ном нь судалгааны энэ сэдвийн хүрээн дэх тоглогчдыг тодорхойлж, боломжийн холбоотнуудыг зааж өгнө.

→ bit.ly/UNForcedEviction

chapatti diagram: ActionAid-ийн энэ хэрэгсэл нь бүлгүүд ба байгууллагуудын хоорондын хүчний харьцаа, хөдөлгөөнийг шинжихэд тусална

→ bit.ly/ChapattiDiagram

Хаалгачин хэрэгсэл: ActionAid-ийн энэ хэрэгсэл нь таны дэвшүүлэх асуудал буюу кампанит ажилтай холбоотой шийдвэр гаргагчдыг танихад тусална

→ <http://bit.ly/gatekeepertool>

4. Аюулгүй байдлыг хангах

Судалгааны баг болон орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг судалгааны ажлын бүх үе шатанд хамгаал. Заримдаа хүмүүс компани буюу засгийн газартай хөгжлийн төслийн талаар ярилцахдаа аюул заналыг хүлээн авдаг буюу бүр хохирол амсдаг. Хөгжлийн төслийн талаар мэдээлэлтэй болох нь хүртэл эрсдэлд оруулдаг тал байна.

Эдгээр эрсдлүүд дээр үндэслэн олон нийтийн судалгаанд хамрагдах сонирхолтой хүн бүр оролцох эсэх дээр бүрэн мэдээлэлтэй шийдвэр гаргасан байх ёстой. Танай судалгааны кампанид анхнаасаа бүх ажлын туршид танай баг бүх болзошгүй эрсдлүүдийг байнга үнэлэн хянаж (холбоотнууд болон нөлөөлөгчдийг эрсдлийг оролцуулан) оролцогч бүрийн эрсдлийг багасгах төлөвлөгөөтэй ажиллавал зохино.

Эрсдлийн талаар багийн гишүүд болон судалгааны оролцогч бүртэй урьдчилан ярилцаж дараа нь тэд оролцохыг хүсч байгаа эсэхийг асууж лавлах. Өөрийн түүх, ойлголтоо хуваалцснаар оролцогчид танд итгэлээ өгч буйн хэрэг, тиймээс ажиллагааны туршид тэдний хувийн мэдээлэл болон өгсөн мэдээллийг хамгаалах. Фото зураг, видео, мэдээллүүдийг хэрхэн ашиглах талаар тайлбарлаж, тэдгээрийг ашиглахаасаа өмнө заавал зөвшөөрөл авч байх.

Эх сурвалжийн
хайрцаг



RESOURCE
BOX



FrontLine Defenders-ээс 11 хэл дээр гарсан [Аюулгүй байдлын ажлын номноос](#) эрсдэлийг ойлгож, аюулгүй байдлыг төлөвлөх аргад суралцана. bit.ly/HRDWorkbook



Tactical Tech-ийн [security in-a-Box](#)-ыг уншиж гар утас болон компьютер дээрх мэдээллийг хамгаалах аргад суралцана.

securityinabox.org/en/tactics/

5. Судалгааны арга хэрэгслийг сонгох

Нийгмийн зураглал гаргах, олон нийтийн мониторинг, судалгаа, асуулга явуулах зэрэг судалгааны олон зэмсэг байдаг. Бидний хэлэлцэх жишээ нь **Нийгмийн төлөөллийн зүгээс хийх судалгааны загвар** юм. Олон нийтийн судалгаа нь ердийн судалгааны адил мэдээлэл цуглуулах төдийгүй олон нийт болон судалгааны багийн хооронд мэдээлэл, санаа бодлоо солилцох боломжийг олгодог. Оролцогчдод судалгааны сэдвийн талаар бүрэн ойлголт өгөх зорилгоор судалгааны баг нь ач холбогдол бүхий нэмэлт мэдээлэл солилцож байх талаар бодолцох хэрэгтэй. Жишээ нь, та төлөвлөж буй хөгжлийн төсөлтэй холбоотой олон нийтийн туршлагыг мэдэхийг хүсч байгаа бол танай улсад хөгжлийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжүүлэлт хэрхэн хийгдэж байгаа талаар мэдээллийг өгч болох юм.

Хэрэв танай баг олон нийтийн судалгаа хийхээр шийдсэн бол асуултууд нь чиг зорилготой, ойлгоход хялбар, хамтран ажиллах байдлаар томъёологдсон байвал зохино. Асуултуудыг "Тийм" эсвэл "Үгүй" хариулттай, боломжит хариултын сонголттой, эсвэл сэтгэгдэл бичих нээлттэй орон зайтай байхаар төлөвлөж болно. Хариултууд нь оролцогчийн хувийн туршлага эсвэл хөгжлийн талаархи хүсэл эрмэлзэл дээр суурилж болно. Олон нийтийн судалгааны асуултууд нь зорилгоосоо шалтгаалан олон сэдвийг хамаарч болно.

Жишээлбэл, нутгийнхан хурдны замын төслийн улмаас гэр орноо алдах магадлалтай бол дараах асуултуудыг тавьж болох юм. Үүнд:

“Таныг нүүлгэвэл танай хүүхдүүдэд яаж нөлөөлөх вэ?”

“Таныг нүүлгэвэл таны ажил болон амьжиргаанд яаж нөлөөлөх вэ?”

“Таныг нүүлгэвэл ямар эх үүсвэр буюу нийтийн газрыг (сургууль, сүм хийд, гол мөрөн г.м.) алдах вэ?”

Асуултууд нь тодорхой, зохион байгуулалттай, ойлгоход хялбар байлгах аар судалгааны төслийг багийн хамт дахин хянах. Багийн бүрэлдэхүүнийг бие биентэйгээ ярилцлага хийх замаар итгэл үнэмшилтэй болгоход нь туслах. Судалгааг дуусгах, нийтийн хурал цуглаан хийх, бүх нийтийн хүртээл болгоход хэдий цаг хугацаа орохыг сайтар тооцоолох.

Хэрэв та хэрэгжсэн жишээ хайж байгаа бол IAP-ийн Global Advocacy Team-д багтах 8 орны идэвхтнүүд нийгмийн судалгаа явуулахдаа зохиосон Нийгмийн төлөөллийн зүгээс хийх судалгааны загвар байна. Нийгмийн төлөөллийн зүгээс хийх судалгааны загвар-ыг тэр чигээр нь эсвэл орон нутгийнхаа нөхцөлд тохируулан шинэчлэж туршиж үзээрэй.

Ашиглах арга хэрэгсэлээ шийдсэн бол цуглуулсан судалгааны мэдээллийг системчлэн зохион байгуулах шаардлага гарна. Судалгааны мэдээллийг системчлэн зохион байгуулах нь судалгааны баг, холбоотнууд, нөхөрлөлийн гишүүдэд судалгааны дүнг цаашдын кампанит ажилд оруулахаас өмнө гүйцэд ойлгож авахад тустай. Зарим ийм програм нь судалгааны өгөгдлийг автоматаар шинжилдэг боловч интернетийн холболт шаардах ба шаардлагатай хэлээр ашиглах боломжгүй байх сул талтай. Зарим нь мөн төлбөр шаардана.



Эх
сурвалжийн
хайрцаг

Data-Center-ийн **Campaign Research toolkits** гэх програм нь зохих арга хэрэгслийг бүрдүүлэхэд тус болно

→ bit.ly/CampaignResearchToolkit

Дараах програмууд судалгааны материалыг зохион байгуулж, шинжихэд тус болно. Үүнд:

survey monkey (www.surveymonkey.com),

Google forms (<https://www.google.com/forms/about/>)

болон **koBo toolbox** (<http://www.kobotoolbox.org/>)

2

Судалгаа

6. Нутгийн иргэдийг бүгдийг хамруулах

Судалгааны баг нь судалгааны явцын туршид **аль болох олон нийтийг шинэ мэдээллээр ханган, тогтмол хамруулж** ажиллах нь чухал. Юуны өмнө, олон нийтийн цугларалт, идэвхит оролцоог хангахын тулд үйл ажиллагаа, цаг хугацааг мэдээлж байх тогтолцоотой болох.

Эхлээд судалгааны багийн төлөвлөө, зорилтуудыг өргөн олон нийтийн хамт хянан шалгах. Судалгааг хэрэгжүүлэхэд бэлэн болсон үед судалгаа хэрхэн хийгдэх талаархи мэдээллийг түгээх. Судалгааны дүнг эцэслэн, цаашдын ажиллагаанд оруулахаас өмнө эхний үр дүнг өргөн нийттэй хуваалцаж хянах. Олон нийтээс үр дүнг хянан шинжиж, цаашдын кампанит ажиллагаанд аль мэдээлэлийг чухалчлахыг эрэмбэлж өгөхийг хүсэх.



RESOURCE
BOX

Communication and Power: CIRAC-ийн энэ програм нь олон нийтийн дотор хэрхэн харилцах олон төрлийн арга, жишээг харуулна.



bit.ly/CommunicationPowerEng

Эх сурвалжийн
хайрцаг

7. Мэдээллийг цуглуулах

Судалгаа хийх газар ба цаг нь оролцогчдод аюулгүй, тухтай, хүрэлцэн очиход дөхөм байх. Оролцогчдод судалгааны талаар бүрэн мэдээлэл

өгөх, мэдээлэл солилцох, асуултанд хариулахад бэлэн байх. Судалгааны зорилго, үйл явцыг оролцогч тус бүрт тайлбарлах.

Нутгийн иргэдийн бүрэн оролцоог хангахын тулд мэдээллийг хэрхэн солилцох, цуглуулах ажиллагааг сайтар төлөвлөх. Жишээлбэл, хэрэв зарим хүмүүс уншиж, бичиж чаддаггүй бол асуулгыг тайлбарлан бөглүүлж хүн бүрийн тэгш оролцоог хангах. Оролцогчид өөрсдийн зураг хөрөг, нэрс, хувийн мэдээллийг нийтэд ил болгохыг хүсч байгаа эсэхийг асуух. Давтахад, судалгаанд оролцогч [нутгийн иргэдийн хувийн мэдээллийг сайтар хамгаалах](#) нь маш чухал.

Оролцогчдыг тодорхойлоход нийгэмлэгийн идэвхтэнгүүдтэй зөвлөлдөж тоог гаргах. Судалгааны баг нь олон нийтийн хэлэлцүүлгэд байнга цөөддөг эсвэл хасагддаг төлөөллийн хүмүүсийг нэгтгэх тал дээр бодолцох хэрэгтэй. Зарим хүмүүс олон нийтийн судалгаанд оролцохгүй байхаар шийдвэрлэвэл судалгааны багийнхан шийдвэрийг нь хүндэтгэхийг баталгаажуулах.

Судалгаанд нутгийн хамт олныг тэр чигээр нь хамруулах боломжгүй байж болно. Ач холбогдол, мэдээлэл бүхий санал бодол хураахын тулд судалгааны асуулгыг дор хаяж 100 хүнтэй хийх зорилго тавина. Аюулгүй байдлыг хангасан тохиолдолд судалгааны баг ганцаарчилсан буюу 10-аас цөөн жижиг бүлгүүдтэй ярилцах, эсвэл шаардлагатай гэж үзвэл ганц хувь хүний бүрэн хариулт, тайлбарыг авах байдлаар ажиллаж болно. Судалгааны багийн гишүүн бүр мэдээлэл цуглуулах ажиллагаанд оролцож, цугларсан мэдээлэл нь тодорхой, тууштай жигд байвал зохино.

Жишээлвэл судалгааны явцад багийн гишүүд асуултыг нэг нэгээр асууж, үл ойлгогдох хариултыг үгэвчлэн тодруулж байх хэрэгтэй. Анхааралтай сонсож, хэн нэгний хариултыг таслан зогсоохгүй ба тайлбар өгөхгүй байх, оролцогч бүрт асуултанд хариулах хангалттай цаг өгөхийг санах. Зарим хүмүүсийн эмзэг туршлагыг сануулахад сэтгэлийн хөдөлгөөнд орж болзошгүй. Дэмжлэгтэй, тэвчээртэй ханд.



RESOURCE
BOX



Transect Walks: CatComm - оос ажиглалтаар нийгмийн харилцааг сайжруулах бүлгүүдэд зориулсан хэрэгсэл

<http://catcomm.org/transect-walk>

Эх сурвалжийн
хайрцаг

8. Судалгааны үр дүнгийн төслийг гаргах ба зөвлөмжүүд

Бүх цуглуулсан мэдээллийг цэгцэлж, үр дүнг тунгаах цаг ирлээ. Хэрэв та судалгаанд дүн шинжилгээ хийх програм ашиглаж байгаа бол судалгааны баг түүнийг туршиж, шалгаж үзэх хэрэгтэй. Хэрэв та программ хангамжгүйгээр шинжлэхээр төлөвлөж байгаа бол явцын үе шат бүрт өөрийн ахиц дэвшлийг хэрхэн тогтоож ажиллахыг шийдээрэй.

Хэрэв асуулга бол таны судалгааны гол хэрэгсэл бол асуулга тус бүрийг дугаарлаж, хуулбарлан ав. Мэдээлэл ба оролцогчдыг хамгаалахын тулд асуулга, хуулбарыг судлах хугацаанд аюулгүй, найдвартай газар хадгалах.

Нэгэнт бүх мэдээлэл нэгтгэн бүртгэгдсэний дараа судалгааны баг алдаа мадаггүйг чандлан шалгана. Хариулт бүр зөв бүртгэгдэж үү? Хариулт сонгох асуулгуудын хариулт бүрийн хувь хэмжээг асуулт бүрээр гаргах.

Хүмүүсийн тайлбар хариултанд тусгайлан анхаарах. Жишээлбэл, албадан нүүлгэгдсэн хүмүүс хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлдэг. Эдгээр туршлагыг баримтжуулж бай – анхаарал татах хувийн түүх нь тооны ард бодит хүмүүсийн амьдралыг харуулдаг.

Хувь хүний түүх нь судалгааг илүү нөлөөтэй, өриймсөг болгодог. Та оролцсон хүмүүсийн талаархи мэдээллийг үргэлж хамгаалах ёстой боловч зарим нь өөрсдийн түүхийг олон нийтэд ил болгохыг хүсч болно. Жинхэнэ нэрийг ашиглахгүй байсан ч тэдгээрийн түүхийг ашиглахаас өмнө тэдний зөвшөөрлийг нь авахыг бүү мартаарай.

Одоо цугларсан мэдээллийг (тайлбаруудыг оруулаад) шинжиж судалгааны зорилгод нийцэх мэдээлэл, чиг хандлага, хэв маягийн зураг гаргаж чадсан эсэхийг хараарай.

Pimatiziwin -ийн **Guide to Qualitative data analysis** хэрэглэвэл мэдээллийг шинжихэд туслана



Эх сурвалжийн хайрцаг



bit.ly/QualitativeDataAnalysis

Capacity Canada-ийн **Storytelling manual**-ыг хэрэглэвэл өөрийн нийгэмлэг дэх түүх дурсамжийг нийтлэхэд тус болно



bit.ly/StorytellingManual

9. Үр дүнгийн эхний төслийг хэлэлцэх

Судалгааны бүх үр дүнгийн эхний төслийг бий болгож, хамт олноороо хэлэлцэх. Үр дүнг хүн бүрт ойлгомжтой байлгах зорилгоор төрөл бүрийн форматаар хийж үзэх хэрэгтэй. Жишээ нь, нийт дунд бичиг үсэг тайлагдаагүй хүн байгаа бол зурагт хуудас хэлбэрээр танилцуулж болно. Тэдний ерөнхий санал хүсэлтийг асуухын зэрэгцээ, ямар үр дүнд тэргүүлэх ач холбогдол өгөх, яаж цаашдын кампанит ажилд хэрэглэх талаар зөвлөмж хүсэх.

Эрсдэлгүй гэж үзвэл судалгаанаас өмнө холбоо тогтоосон холбоотон, нөлөөлөгчдөд үр дүнгээ танилцуулах. Нийтэд ил болгохоос өмнө тус болно гэж үзвэл тэдний зөвлөмжийг авч тусгах. Гэсэн ч тэдний санал нь орон нутгийнхны санал болгосонтой зөрчилдөх ёсгүй. Судалгааны бүх дүнг нэгтгэсний дараа цаашдын сурталчилгааны зорилтуудад нийцүүлэн аль асуулга, судалгаанд тэргүүлэх ач холбогдол өгч кампанит ажилд хэрэглэхийг тогтох.

IAP's Global Advocacy Team-ээс гаргасан Нийгмийн төлөөллийн зүгээс хийх судалгааны загвар-ыг ашиглан судалгаа явуулсан дэлхийн олон нийтийн зохион байгуулагчдын туршлагатай танилцаарай



Эх
сурвалжийн
хайрцаг

→ **Community-led Research: Sukhgerel's story**
bit.ly/sukhgerelstory

→ **Community-led Research: Elias' story**
bit.ly/eliasstory

→ **Community-led Research: Mela's story**
bit.ly/melasstory



Сурталчлах

10. Судалгааны эцсийн дүн, зөвлөмжийг хэлэлцэх

Одоо, судалгааны дүнг кампанит ажилруу шилжүүлэх цаг ирлээ!

Бэлтгэх шатанд гол хүлээн авагчдыг тодорхойлсон тул судалгааны үр дүн, зөвлөмжийг нийтэд хүргэх өөрсдийн стратегийг тогтох хэрэгтэй. Жишээлбэл, хэрэв та орон нутгийн шийдвэр гаргагчид нөлөөлөх нь эрсдэлгүй гэж үзсэн бол судалгааны үр дүнг орон нутагтаа таниулах арга хэмжээ зохион байгуулж зураг, видео бичлэгээр баримтжуулахыг бодолцох хэрэгтэй. Хэрвээ зорилтот бүлгүүд нь танай орон нутаг буюу улс орны гадна байгаа бол харилцаатай холбоотнуудынхаа зөвлөмж, туслалцааг авч хүргэх хэрэгтэй.

Өөрийн нөлөөлөхийг хүсч буй хүмүүсийг сайтар шинжиж, судалгаа, зөвлөмжийг хэрхэн хүргүүлж, хэрхэн тэдгээрийн хариу үйлдлийг авах талаар бодолцох хэрэгтэй. Судалгааны багийнхан болон нийт олон судалгаа, зөвлөмжийг хэрхэн нийтэд хүргэхээр шийдсэн дээр дахин бодолцох. Бичмэл тайлан хэлбэр нь хамгийн зохистой нь мөн үү? Хэрвээ тийм бол хэр урт байхав, ямар формат нь уншиж ойлгоход дөхөмтэй байхав? Өөрийн биеэр танилцуулах уу, эсэргүүцлийн самбар хийх үү, видео, график үзүүлэн эсвэл вэбсайт дээр гаргах уу? Найз нөхөд танд туслах болно. Видео засварлагч, график дизайнер, зураач зэрэг сайн дурын холбоотнууд туслаж болно. Бодлоготой бүтээлч бай!



RESOURCE
BOX

Эх
сурвалжийн
хайрцаг

Хөгжил гэх дээр эргэн ирэх нь: IAP-ийн **A Call for What Development Could Be** илтгэлд 8 нийгмийн төлөөллийн идэвхитэн өөрийн судалгааны ажлыг танилцуулна

→ bit.ly/whatdevelopmentcouldbe

The Mobilisation Cookbook-ийг хэрэглэх: Moblab-аас өөрийн олсон зүйлийг томоохон кампанит ажил болгон ашиглах зааварчилга

→ bit.ly/MobilisationCookbook

Tactical Tech-ийн **Visualizing information for advocacy** зааварчилгааны эцсийн бүлгээс өөрийн мэдээллийг зурагт үзүүлэн болгохыг сурна

→ bit.ly/VisualisingForAdvocacy

The Change Agency-ийн **Critical Path Analysis** нь өөрийн тань судалгааны дүнг утга бүхий өөрчлөлт болгох дээр санаа өгнө

→ bit.ly/changeagency

11. Хамтдаа арга хэмжээ ав!

Судалгааны дүн, зөвлөмжийг хуваалцах нь өөрчлөлтийг шаардах нэг алхам боловч, хөгжлийн төлөвлөгөө, санаануудыг бусдад мэдээлж, тэднийг идэвхижүүлэх нь мөн чухал болно.

Олон нийтийн судалгааны явцад анх тогтоосон цаг хугацааг баримталж, үе шат бүрийг тогтмол хянан, шаардлагатай бол ялалт, шинэ боломжийг ашиглах тохируулга хийж ажил.

Бусад нийгэмлэг, нийгмийн хөдөлгөөн, иргэний нийгмийн бүлгүүд таны судалгаа, зөвлөмжүүд дээр суралцах сонирхолтой байх магадлалтай.

Тэдэнтэй туршлагаасаа хуваалцахыг бодолцоно уу!



Эх
сурвалжийн
хайрцаг

IAP's Community action Guide to the Asian Development Bank

нь өөрийн судалгааны дүнг ашиглан ямар арга хэмжээ авч болох тал дээр санаа өгнө

→ bit.ly/Adbguide

Repeal the Deal Productions-ын **Counting our Victories** гэх олон нийтийн сургалт, зохион байгуулалтын зааварчилгаа нь судалгааны сэдвээр хүмүүсийг зохион байгуулах, сургахад туслана

→ bit.ly/CountingOurVictories

ActionAid's Bridge –ийг хэрэглэж арга хэмжээг төлөвлөн хөгжүүлэхэд суралцах

→ bit.ly/actionbridge

12. Эцсийн дүгнэлт

Сурталчилгааны ажиллагаа эхэлсний дараа судалгааны багийн зүгээс кампанит ажлын зорилгод хүрэх ахиц дэвшлийг хэмжих, ажиллах хэд хэдэн цагийн зааг тогтоож өгөх. Судалгааны багаас судалгааныхаа нийт үйл явцын талаар эргэцүүлэн бодож, зорилгодоо хүрэх замын хаана байгааг хэмжиж, шинэ сорилтуудын талаар болон дараагийн алхмууддаа ямар нэгэн тохируулга хийх талаар хэлэлцэж байхыг хүсэх. Ийнхүү дүгнэн цэгнэх нь хувь хүн болон өргөн олны хувьд сургамж, ахицтай туршлага болох талтай. Судалгааны үйл явцын үе шат бүр болон кампанит ажил дуусахад ийнхүү эргэцүүлэлт хийж байх хэрэгтэй.



Эх сурвалжийн
хайрцаг

Counting Seeds for Change-ийг ашиглах: SARN-ын **Reflect evaluation framework**-ийг ашиглан судалгааны үйл явц, кампанит ажлыг цэгнэхэд тустай

→ bit.ly/CountingSeedsForChange

Та одоо энэ 12 алхмыг давлаа гэж бодвол олон нийтийн судалгааны талаар ойлголттой болж хэрхэн үүнийг өөрөө гүйцэтгэхийг мэдэж авлаа гэж үзнэ. Олон нийтийн судалгаа бүрийг нийгэмлэгүүд өөр өөрөөр зохион байгуулдаг – түүнд л бахархмаар!

**Та өөрийн олон нийтийн судалгааг эхлэхэд бэлэн үү?
Энэхүү хяналтын жагсаалтыг аяллынхаа луужин болго!**

INTERNATIONAL
ACCOUNTABILITYPROJECT

accountabilityproject.org
